



УЛААНБААТАР ХИВС
хувьцаат  компани

**“УЛААНБААТАР ХИВС” ХУВЬЦААТ
КОМПАНИЙН 2022 ОНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

Улаанбаатар хот.

2022.04.04.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ !

Монгол улсын Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн дагуу “Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 06-ны өдрийн 11.00 цагт компанийн хурлын танхимд хийнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурал зохион байгуулах комисс

Комиссын дарга: Утас: 88023515, e-mail: battsetsegnambar@gmail.com

Гишүүд : Утас:70142556, 80080181

Факс :11-343311,

e-mail : ubcarpet@gmail.com

Web site : www.mongolia-carpet.mn

**“Улаанбаатар хивс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2022 оны ээлжит хурлын хэлэлцэх асуудал**

- 1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны үр дүн, 2022 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай**
- 2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт**
- 3. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2022 оны зардлын төсөв батлах тухай**
- 4. Компанийн ТУЗ-ийн сонгууль явуулах**

Хурлын дэг

1. Хурлын ирцийг бүртгэж, мэдээлэх
20 минут /10.40-11.00/
2. Хурал нээж, хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга нарыг сонгох
5 минут
3. Хурлын хэлэлцэх асуудал, хурлын дэг тогтоох
Хурлын тэргүүлэгчид
10 минут
4. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны үр дүн, 2022 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай
Илтгэгч ТУЗ-ийн дарга Ц.Зоригт
20 минут
5. “Улаанбаатар хивс” ХК-ийн санхүүгийн тайлан аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
Илтгэгч: ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны гишүүн/ 10 минут
6. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2022 оны зардлын төсөв батлах тухай
Илтгэгч: ТУЗ-ийн н. б. дарга Н.Батцэцэг
10 минут
 1. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн сонгуульд нэр дэвшигчдийг танилцуулах
Хурлын дарга Ё.Энхтөр
10 минут
8. Хэлэлцсэн асуудлын талаархи санал, шүүмжлэл
Хурлын тэргүүлэгчид
Хүн тус бүрд 5 минут/
9. Хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг танилцуулах
Тооллогын комисс
30 минут
10. Хурлын шийдвэрийн төслийг батлуулж, хурал хаах
Хурлын тэргүүлэгчид
10 минут

Хурлыг 04-р сарын 06-ны өдөр 11.00 – 14.00 цагт багтаахаар төлөвлөсөн.



“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын машины аргаар хивс нэхэх анхны үйлдвэр болох “Улаанбаатар хивс” ХК нь 1971 онд БНАГУ-ын /хуучин нэрээр/ техник эдийн засгийн тусламжтайгаар баригдаж, жилд 2 ээлжээр 350.0 мянган м² хивс үйлдвэрлэх хүчин чадалтай ашиглалтанд орсон бөгөөд 1978 онд бүрэн хүчин чадлынхаа хэмжээнд хүрч ажилласан. Үүнээс хойш 1979-1980 онуудад нэхэх цехийг, 1989-1990 онд ээрэх цехийг тус тус өргөтгөсөн. Тус компани нь 1992 онд 100 хувь хувьчлагдаж, хувьцаат компани болсон ба одоо 895 хувьцаа эзэмшигчидтэй.

Компани нь одоогийн байдлаар 110 гаруй ажилчидтай, хонины ноосыг угааж, угаасан ноосоор ээрмэл утас бэлтгэн төрөл бүрийн өнгө, дизайнтай Алтанбулаг, Алтан-Өргөө, Саян, Сутай, Улаанбаатар нэртэй цэвэр ноосон хивс үйлдвэрлэж дотоод, гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлдэг. Үүнээс гадна захиалгат хивс, эсгий гудас, машины суудлын бүрээс, улавч, тааран цүнх, килим /ноосон бүтээлэг/ зэрэг бусад туслах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэж байна.

“Улаанбаатар хивс” ХК-ийн эрхэм зорилго

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, сонирхлыг эрхэмлэн дээдэлж, хивсний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн чанартай сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаж, улмаар улс нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах нь компанийн эрхэм зорилго юм.

“Улаанбаатар хивс” ХК нь 50 жилийн түүхт ойн жил болох 2021 онд хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрүүдийг хэрэгжүүлж, ТУЗ-өөс техник, технологийн шинэчлэл хийх, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, гадаад дотоодын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн олон нэр төрлийн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлээ тэлэх зэрэг үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, компанийн нийт ажилтнууд, хамт олны хүч хөдөлмөрийг зүй зохистой зохион байгуулж ажиллаж ирлээ.

Манай компани нь 2022.03.10-ны бүртгэлийн өдрөөр:

- Үнэт цаасны 47 БДК-ийн 895 хувьцаа эзэмшигчтэй
- Компанийн зах зээлийн үнэлгээ 18,2 тэрбум төгрөг буюу өнгөрсөн онтой харьцуулахад 90,7 % өссөн байна.
- Өнгөрсөн 52 долоо хоногийн дундаж үнээр нэгж хувьцааны үнэ 23500-47800 төгрөгийн хооронд хэлбэлзэж,
- Нийт хувьцааны 95,4 хувь нь 8 хувьцаа эзэмшигчид төвлөрдөг ба 16 гадаадын иргэд, компаниуд цөөн тооны хувьцааг эзэмшдэг.
- Бид 2020 оны ажлын үр дүнгээр нэгж хувьцаанд 600 төгрөг буюу нийтдээ 242,9 сая төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдийн дансанд шууд олгосон болно.
- Тайлант 2021 оны ажлын үр дүнгээр нэгж хувьцаанд 1200 төгрөг буюу 485,8 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар компанийн ТУЗ-өөс шийдвэрлэж ноогдол ашгийг олгоод байна.
- Бид компанийн тухай, үнэт цаасны тухай хууль, журмыг мөрдөж, МХБ болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагуудтай зохих ёсоор хамтран ажиллаж, холбогдох гэрээ, мэдээ, тайлан, төлбөр тооцоог зохих журмын дагуу хэрэгжүүлж ирсэн.

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2019-2022 он хүртэлх хувьцааны хөдөлгөөнийг харуулбал,

АРИЛЖААНЫ МЭДЭЭ АРИЛЖИГДСАН ТҮҮХ



Улаанбаатар хивс ХК (UBH)

44120 ↔ 0 (0.00%)

Өмнөх өдрийн хаалт:	44,120.00	Өдрийн хязгаар:	0.00 - 0.00
Нээлтийн ханш:	0.00	Арилжигдсан ширхэг:	0
Хаалтын ханш:	N/A	Арилжааны үнийн дүн:	0.00
Тухайн өдрийн VWAP:	0.00	Хэлцлийн тоо:	0
Авах дээд үнэ:	37,800.00 x 6	52 долоо хоног:	23,500.00 - 47,800.00
Зарах доод үнэ:	47,800.00 x 100	ISIN:	MN00UBH00079
Нийт гаргасан хувьцаа:	404,829	Зах зээлийн үнэлгээ:	17,861,055,480.00
Эргэлтэд гаргасан хувьцаа:	404,829		



2021 онд Covid-19 цар тахлын улмаас, компанийн ТУЗ 1 удаа танхимаар хуралдаж, цахим шуудангаар 2 удаа асуудал шийдүүлж ажиллалаа.

ТУЗ-ийн даргын хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийн ажилд биечлэн оролцож, гүйцэтгэх удирдлагатай хамтдаа идэвхитэй ажиллаж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг газар дээр нь хэлэлцэн шийдвэрлэж ажилласан байна.

Тухайлбал, бэлэн бүтээгдэхүүний цахим борлуулалт, мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх, материал, түүхий эд, ноос бэлтгэл, санхүүжилт, ажлын байрны дотоод тохижилт, эрүүл ахуй нөхцөлийг сайжруулах, техник, технологи, сантехникийн шугам сүлжээг засварлах зэрэгт ихээхэн анхаарал тавьж ажилласан.

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2021 оны

үйл ажиллагааны тайлан

Тайлант онд “Улаанбаатар хивс” ХК-ийн хамт олон дараахь үндсэн үзүүлэлттэй ажиллав:

- **35459 м2 хивс үйлдвэрлэж 48296 м2 хивс борлуулсан** нь үнийн дүнгээр **4 679,5 сая төгрөгт хүрч**, урьд оноос 1 282,9 сая төгрөгөөр өсөв.
- **732,7 сая төгрөгийн цэвэр ашигтай** ажилласан нь өмнөх оныхоос 414,7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дээрх үр дүнд хүрэхэд компанийн нэгж, албад дараахь ажлуудыг гүйцэтгэв.

- Үйлдвэрлэлийн алба:

- Тайлант 2021 онд нийт 267,7 тонн ноосыг Увс, Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл зэрэг аймгуудаас 670,2 сая төгрөгөөр худалдан авлаа.
- Ноос бэлтгэлд 4 аймгийн 15 төлөөлөгчтэй гэрээр хийж, 1100 малчны ноосны падааныг урамшууллын программд шивж илгээв.
- Ээрэх цехэд :
 - 12/3 номерын утас 8065 кг
 - 15/3 номерын утас 63075 кг-ийг тус тус ээрч үндсэн үйлдвэрлэлээ хангаж ажилласан.
 - Мөн хялгас ялгах цехэд 4113 кг ноос ялгаж 25,8%-ийн гарцтай байлаа.
- Нэхсэн хивсийг нэр төрлөөр үзүүлбэл:
 - Алтанбулаг 23836 м2 буюу 68,4 %
 - Саян 4635 м2 буюу 13,3 %
 - Алтан-Өргөө 208,0 м2 буюу 0,6%
 - Улаанбаатар 6188 м2 буюу 17,7 % байна.
- Оёдлын тасагт гудас, түшлэгтэй, түшлэггүй сандлын хивс, тааран уут, хивсэн углааш, ажлын хувцас зэргийг үйлдвэрлэн борлуулалтанд тушаалаа.
- Эсгий цехэд 2 м өргөнтэй самнах машин худалдан авч суурилууллаа.

- Хялгас ялгах цехэд чийгшүүлэгч аппарат 2 ширхгийг авч суурилуулав.
- Нэхэх машин дээр килим нэхэж, “Монгол нэхмэл” ХХК-аар үслүүлэн борлуулах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүллээ.
- “Монхорус” ХХК”- хамтран эрчим хүч хэмнэх “ЭСКО” төсөл хэрэгжүүлж, 4 ширхэг давтамж хувиргагч суурилуулан агааржуулалтын эрчим хүчийг 30% хэмнэх тооцоо гараад ажиллаж байна .
- Сургалтын танхим, цехүүдэд вакуум хаалт, хийн хоолой, цехийн шалыг резиндэх, цайны өрөө, хаягжилт, тоног төхөөрөмжийг будах зэрэг ажлын байрны эрүүл ахуй, эмх цэгцийг сайжруулах олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- **Маркетингийн алба**

- Нэрийн барааны дэлгүүрийн үйлчлэх талбайг 200,0 м²-аар нэмэгдүүлэн тохижуулсан.
- Компанийн дэлгүүрт 280*260 хэмжээтэй гэрэлт самбар байрлуулав.
- Компани үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойд зориулж, 4 минутын видео кино, нэвтрүүлэг, богино хэмжээний рекламуудыг 3 ТВ-ээр 72 удаагийн давтамжтайгаар хэрэглэгчдэд хүргэсэн.
- “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэнд амжилттай оролцов.
- Нийт борлуулалтанд захиалгат борлуулалт 3,5%-ийг эзэлсэн ба захиалгын үнийн дүнгийн 70,0% нь байгууллагын захиалга байлаа..


- **Сургалт, хүний нөөцийн алба**

- 2021 онд компани дунджаар, 114 ажилтантай ажиллаж байгаа ба өнгөрсөн онд 26 хүн ажилд шинээр авч, 26 хүн халагдсан , шинэ ажилтны тогтвор суурьшил 58% байсан нь өнгөрсөн жилийнхээс 13% илүү байна.
- Нийт ажилтнуудын дундаж нас: 47 нас, тэтгэврийн насны ажилтнууд нийт ажилтнуудын 32,5%-ийг эзэлж байна.
- Компанийн үйлдвэрлэлийн талаар ерөнхий мэдлэг олгох хөтөлбөр боловсруулж, 20-оод ажилтнуудыг хөтөлбөрт хамруулав.

- Компанийн түүхт ойтой холбогдуулан, тэргүүний ажилтнуудыг урамшуулах, идэвхжүүлэх, алдаршуулах зорилгоор 39 ажилтныг төр, засгийн шагналд тодорхойлж 24 ажилтан шагнагдсаны дотор МУ-ын Аж Үйлдвэрийн Гавьяат ажилтан 2 төрөв.



*Монгол улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан
хэмээх эрхэм цол хүртсэн
Ч.Цэрэндулам, Ч.Сарантуяа нартаа
халуун баяр хүргэе*



- Цар тахлын улмаас компани 40 хоног бүрэн зогсож, сул зогсолтын хөлсийг хууль журмын дагуу олгосон.
- Компанийн хэмжээнд Ковид-19 өвчний илрэлтийн тохиолдол 20 гаруй бүртгэгдсэн ба хөдөлмөрийн чадвар алдалт 2020 онтой харьцуулахад 3 дахин өссөн байна.
- Сургалтын кабинетийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглов.
- Царай таних цаг бүртгэлийн аппарат шинээр суурилуулан ашиглаж байна.

- Санхүү-эдийн засгийн алба

- “Номин холдинг” ХХК-тай түрээсийн гэрээний харилцан тохиролцооны дагуу 2021 оны 09-12-р саруудад дээврийн засварын 50%-ийн тооцоог хийж түрээсийн төлбөрөөс суутган тооцсон.
- Баянхонгорт авсан 127070 кг ноос буюу 329,8 сая төгрөг, Улаанбаатарт авсан 140680 кг баюу 340,4 сая төгрөг, нийт 267,7 тн буюу 670,2 сая төгрөгийн тооцоог хийж бүртгэлд тусгасан. Мөн ноосны НӨАТ-ын буцаан авалтын тооцоог малчин бүрээр нь хийж татварын авлагаар тайланд тусгасан.
- ХААН банкны Корпорейт гейтвэй үйлчилгээнд бүргүүлснээр харилцахын хуулгыг санхүүгийн программд шууд татан оруулах, татвар гаалийн гүйлгээг шууд интернет банкаар шилжүүлэх боломжтой болсон ба Qрау аппликейшнд бүртгүүлэн ноосны падааны төлбөрийг шууд малчны данс руу шилжүүлэн, ноосны НӨАТ буцаан олголтыг боломжтой болгосон.
- Ковидоос шалтгаалсан, нийт 40 хоногийн зогсолтын тооцоог хийж, 46,2 сая төгрөгийг олгосон.
- “Ноос ирээдүй” ХХК-иас 2 удаа 6,8 сая төгрөгийн эсгий худалдан авч өртгийг тооцон, үйлдвэрлүүлж, худалдаанд гаргасан.
- Турк улсаас онлайнаар 4,0 сая төгрөгийн гэр ахуйн бараа, иргэн Наранцацралтаас эсгий тапочкины материал тус тус худалдан авч нэрийн барааны дэлгүүрээр борлуулж, тооцоог сар бүр хийсэн.
- Хөрөнгийн үнэлгээг төв компаниар хийлгэж, 2021-01-р сарын 1-нээс үндсэн хөрөнгийн бүртгэлийг шинэчлэн бүртгэлд тусгасан.
- Үйлдвэрийн 5 давхарт барилгын засвархийсэн Момд ХХК-тай тооцоо хийж үндсэн хөрөнгөнд 107,6 сая төгрөг орлогод бүртгэсэн.

- Компанийн 50 жилийн ой тэмдэглэх ажилд албаараа идэвхтэй оролцож, 50 жилийн үйл ажиллагаанд тоон үзүүлэлтээр график дүгнэлт хийх, зардлын төсөв тооцоо гаргах, ажилтнуудын шагнал урамшуулал олгох зэрэг бүх ажлуудыг хийлээ.

Бусад ажлууд

- Компанийн оффисийн 5 давхар болон үйлдвэрийн барилгын фасадыг засав.
- Компанийн оффисын 1,2, 4, 5 давхруудыг засч шинээр түрээслэв.
- Ажилчдын байрны ариун цэврийн өрөөнд засвар хийж, сантехникийг шинэчлэв.
- Үйлдвэрийн барилгын дээврийн 5400 м2 талбайд мембранаар засвар хийлгэв.
- Эдгээр болон бусад олон ажлуудыг компанийн түүхт ойг угтах, ажилтнуудын ажлын байрны нөхцлийг сайжруулах хүрээнд хийж гүйцэтгэв.
- Компанийн 50 жилийн ойн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, ахмад ажилтнууд, харилцагчид, үр бүтээлтэй ажиллаж байсан ба одоогийн ажилтнууд зэрэг 340 орчим хүний хүлээн авалт зохион байгуулж, нийт зочдыг гарын бэлгээр урамшуулав.

2022 оны үйл ажиллагааны үндсэн зорилт, үзүүлэлт

2022 онд цар тахлын үе дэх зах зээлийн хандлага, эдийн засгийн нөхцөл болон бусад нөлөөллүүдийг тооцон дорхи үндсэн үзүүлэлтүүдийг ханган ажиллах зорилго тавьж байна.

- **Үйлдвэрлэлт** **51 000,0 м2**
- **Борлуулалт** **5 300 сая төгрөг**
- **Хөрөнгө оруулалт** **500 сая төгрөг**
- **Цэвэр ашиг** **800 сая төгрөг**
- **Үйлдвэрлэлийн нэгж өртөг** **89 300 төгрөг**

Манай компанийн хамт олон Монгол улсад машинт аргаар хивс үйлдвэрлэж эхэлсэн буюу тус компани үүсэн байгуулагдсаны хоёр дахь хагас зуун жилдээ шилжин орж байгаа 2022 онд үйлдвэрлэл технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанар, сав баглаа боодлыг сайжруулж, гадаад дотоод харилцаа, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлэхэд анхаарал тавьж тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэн ажиллах болно.

Бид монгол хонины цэвэр ноосон утсаар нэхсэн хивс дэлхийн өнцөг булан бүрд хүрч, хивсний илч дулаан, таатай мэдрэмжийг хэрэглэгчдэд бий болгохын төлөө ажиллана.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

RSA

“РЕЛАЗНС СЕКЮРИТИЗ
АУДИТ” ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
9-р хороо Компьютер молл 7024 тоот
Утас: 99813174
E-mail: rsamongolia@gmail.com

2022.03.28 № 022/071
Танай _____ -ны № _____ -т

“ Улаанбаатар хивс “ ХК
-ийн Удирдлага-д

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “ Улаанбаатар хивс ” ХК-ийн 2021 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлан тэнцэл, санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “ Улаанбаатар хивс ” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлан, үйл ажиллагааны үр дүн , өмчийн өөрчлөлт , мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг .

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуулыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд , тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бид аудитын нягтлах ажлыг хийх явцдаа доорхи АОУС-уудыг мөрдөж ажиллалаа.

Үүнд: АОУС500, АОУС510, АОУС530...

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, толилуулах нь компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын зүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

05/09
(Энэхүү тайлан нь *...* тоот хавсралтын хамт хүчин төгөлдөр болно)



"Улаанбаатар хивс" ХХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
 2021 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	603,696.0	1,376,093.2
1.1.2	Дансны авлага	27,174.2	30,068.6
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	6,418.3	36,195.9
1.1.4	Бусад авлага	7,089.2	8,425.3
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,908,684.3	1,491,270.0
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,154,518.0	1,235,061.0
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,707,580.0	4,177,114.0
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,368,604.3	10,210,507.9
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,920.0	1,920.0
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,370,524.3	10,212,427.9
	Нийт хөрөнгийн дүн	9,078,104.3	14,389,541.9

Аудитор



Б.Мягмар



"Улаанбаатар хивс" ХХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
ӨМЧ, ӨР ТӨЛБӨР

2021 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	87,000.4	67,255.5
2.1.1.2	Цалингийн өглөг	25,141.40	43,182.40
2.1.1.3	Татварын өглөг	52,610.6	60,569.8
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,091,071.5	997,269.0
2.1.1.6	Хүүний өглөг	570,350.80	570,320.40
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	2,119.80	2,119.80
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	60,263.1	11,845.7
2.1.1.9	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.10	нөөц өр төлбөр		
2.1.1.11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,888,557.6	1,752,562.6
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл	248,000.0	112,727.3
2.1.2.2	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.3	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Урт хугацаат өр төлбөрийн дүн	248,000.0	112,727.3
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,136,557.6	1,865,289.9
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	-хувийн		-
2.3.2	-хувьцаат	40,482.9	40,482.9
2.3.3	Халаасны хувьцаа		
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал	34,161.7	34,161.6
2.3.5	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,707,643.00	11,800,563.50
2.3.6	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.8	Хуримтлагдсан ашиг	159,259.1	649,044.0
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,941,546.7	12,524,252.0
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	9,078,104.3	14,389,541.9

Аудитор

Б.Мягмар

РЕЛЭНС
 СЕКЮРИТИЗ АУДИТ ХХК
 Page: ... 04

"Улаанбаатар хивс" ХХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
 2021 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2021.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,679,468.2
2	Борлуулалтын өртөг	3,719,702.8
3	Нийт ашиг (алдагдал)	959,765.4
4	Түрээсийн орлого	565,784.4
5	Хүүний орлого	15,624.6
6	Ногдол ашгийн орлого	
7	Эрхийн шимтгэлийн орлого	
8	Бусад орлого	212,923.5
9	Борлуулалт, маркетингийн зардал	433,904.5
10	Ерөнхий ба удирдлагын зардал	181,809.0
11	Санхүүгийн зардал	
12	Бусад зардал	324,692.0
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,572.6
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-884.0
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	
17	Бусад ашиг (алдагдал)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	814,381.1
19	Орлогын татварын зардал	81,698.8
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	732,682.3
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	732,682.3
23	Бусад дэлгэрэнгүй орлого	
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	
23.3	Бусад олз (гарз)	
24	Орлогын нийт дүн	732,682.3
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	

Аудитор

Б.Мягмар



"Улаанбаатар хивс" ХХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2021 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

№	Үзүүлэлт	Өмч	Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	Хөрөнгийн дахин үнэлгээ	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	/Мянган төгрөг/	
							Нийт дүн	
1	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	40,482.9		6,707,643.0	34,161.7	159,259.1	6,941,546.7	
2	Нөхтөл бодох бүртгэлийн борлогын өөрчлөлийн нөлөө, алдааны залруулга							
3	Тайлант үеийн цэвэр ашиг (агцдагдал)							
4	Бусад дэлгэрэнгүй орлого					732,682.3	732,682.3	
5	Өмчид гарсан өөрчлөлт							
6	Зарласан нэгдэл ашиг							
7	Урлаг үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн							
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	40,482.9		11,800,563.4	34,161.0	649,044.0	12,524,252.0	



Handwritten signature

Аудитор

Б Мянгам

"Улаанбаатар хивс" ХХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2021 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2021.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн	5,738,820.8
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,568,430.7
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	
1.1.4	Буцаан авсан албан татвар	
1.1.5	Бусад мөнгөн орлого	170,390.1
1.2	Мөнгөн зарлагын дүн	4,523,762.7
1.2.1	Ажиллагчдад төлсөн	932,480.1
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	240,500.0
1.2.2	Бараа материал худалдан авахад төлсөн	2,135,216.0
1.2.2	Ашиглалтын зардалд төлсөн	25,015.3
1.2.3	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,397.8
1.2.4	Хүүний төлбөрт төлсөн	15,580.8
1.2.4	Татварын байгууллагад төлсөн	678,048.0
1.2.4	Даатгалын төлбөрт төлсөн	
1.2.5	Бусад мөнгөн зарлага	491,524.7
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,215,058.1
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
2.1	Мөнгөн орлогын дүн	15,624.6
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	15,624.6
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	
2.1.8	Бусад	
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	
2.2.4	Валютын ханшийн зөрүү	
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,624.6
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
3.1	Мөнгөн орлогын дүн	1,502.0
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
3.1.3	Ханшийн тэгшитгэлийн олз	1,502.0
3.1.4	Бусад	
3.2	Мөнгөн зарлагын дүн	459,787.5
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	229,022.7
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	
3.2.4	Төлсөн ногдол ашиг	230,752.5
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	12.3
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(458,285.5)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	772,397.2
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	603,696.0
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,376,093.2

Аудитор

Handwritten signature

Б.Мягмар

РЕЛЭНС
 СЕКЮРИТИЗ АУДИТ ХХК
 Page... 04

Төсөл

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа
эзэмшигчдийн
2022 оны 4-р сарын 06-
ны өдрийн хурлын
Тэргүүлэгчдийн
3\2022 тоот тогтоолын

Хавсралт №01

ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны
зардлын төсөв.

№	Зардлын товч утга	Нийт дүн /₮
1	Цалин, урамшуулал	7800000
2	Тээвэр, шатахуун, сэлбэг	400000
3	Бичиг хэрэгсэл, үйлчилгээний зардал	800000
4	Хэвлэл, холбоо, интернетын зардал	2000000
5	Хянан шалгалт, томилолтын зардал	1500000
6	Бусад сургалт, аттестатчилал	1000000
	Д ү н	13500000

“Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн Гишүүдэд нэр дэвшигчдийн товч намтар

1. Цоодолын ЗОРИГТ

- 1955 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1973 онд ерөнхий боловсролын дунд сургууль
- 1978 онд МУИС-ийн Политехникийн Дээд сургууль, аж үйлдвэрийн эдийн засагч мэргэжилтэй
- 1991 онд Удирдлагын хөгжлийн Институт төгссөн
- 1978-1998 онуудад Эрдэнэтийн Уулын Баяжуулах үйлдвэрт эдийн засагч, ахлах эдийн засагч, хэлтсийн орлогч дарга, дарга, орлогч захирал
- 1998-2001 онд “Мазар” ХХК-ийн захирал
- 2001 оноос “Орхон хийц” компанийн захирал.
- 2008 оноос “Улаанбаатар Хивс” ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

2. Шагдарсүрэнгийн УЛАМБАЯР.

- 1967 онд Улаанбаатар хотод төрсөн.
- 1975-1986 онд ОХУ, Москва хотод Ерөнхий боловсролын сургууль
- 1986-1993 онд Украин улсын Киевын Политехникийн их сургууль, Радио Холбооны инженер, бакалавр, магистрын зэрэгтэй
- 2004-2006 онд АНУ-ын New Jersey-н Rutgers их сургууль/ БНХАУ-ын Бээжин салбарт/, олон улсын Бизнесийн удирдлагын магистрийн зэрэг
- 1994-2002 онд “Номин Трейд” ХХК-д дэд захирал
- 2002 оноос “Номин Холдинг” ХХК-ийн Үйлдвэрлэлийн бизнес эрхэлсэн захирал
- 2003 оноос “NCD Групп”-ийн ерөнхий захирал
- Ам бүл 5, эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг.

3. Лувсангийн ЦЭНДЭЭХҮҮ

- 1955 од Сэлэнгэ аймгийн Мандал суманд төрсөн.
- 1973 онд Зүүнхараа хотын 10-н жилийн 1-р дунд сургууль төгссөн.
- 1978 онд МУИС-ийн дэргэдэх Политехникийн дээд сургуульд суралцсан,
- АҮ-ийн инженер эдийн засагч мэргэжилтэй.
- 1978-2001 онд Монгол –Оросын хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрт эдийн засагч, ахлах эдийн засагч, товчооны даргаар ажиллаж байсан.

- 2001-2019 онд “Мазар” ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 2019 оноос “Стандарт ноос” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

4. Зоригтын **МӨНХМАА**

- Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотод 1977 онд төрсөн.
- 1985- 1995 ерөнхий боловсролын сургууль
- 1995- 2002 онд БНХАУ-ын Бээжин хотын химийн технологийн дээд сургууль төгссөн, химийн үйлдвэрийн технологич мэргэжилтэй, бакалавр.
- 2002-2004 онд "Цайрт минерал" ХХК-д мэргэжилтэн
- 2004-2008 онд "Улаанбаатар хивс" ХК-д чанарын инженер, маркетингийн албаны дарга
- 2008- 2013 онд АНУ-д гэр бүлийн хамт амьдарсан.
- 2013 оноос хойш "Улаанбаатар хивс" ХК-д дэд захирал.
- Орос, англи, хятад хэлтэй.
- Нөхөр, 4 хүүхдийн хамт амьдардаг.

5. Шагдарсүрэнгийн **ЭНХБАЯР**

- 1975 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1982-1992 онд ерөнхий боловсролын дунд сургууль
- 1992-1996 онд МУИС-ийн ЭЗДС-ийг нябо-эдийн засагч мэргэжлээр төгссөн
- 2005-2006 онд АНУ-ын Калифорнын UCSB их сургууль, англи хэлээр
- 2009-2011 онд УБ хот,Эрдэм Оюу Дээд сургуульд Бизнесийн удирдлагын магистрийн зэрэг хамгаалсан.
- 2011 оноос АНУ-ын New Jersey-н Rutgers их сургууль / БНХАУ-ын Бээжин салбарт/ Олон улсын Бизнесийн удирдлагын магистрийн зэрэг
- 1996-1997 онд ТӨХ-ны БХННормативын Газар мэргэжилтэн
- 1997-2002 онд “Номин Трейд” ХХК-д дэд захирал.
- 2002- 2003 онд “Интер” банкны дэд захирал
- 2003-2013 онд “Номин Холдинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 2013 оноос “NTG Групп”-ийн ерөнхий захирлаар ажиллаж байна.
- Ам бүл 5, эхнэр 3 хүүхдийн хамт амьдарч байна.

6. Зоригтын ЭРДЭНЭ

- 1985 онд Эрдэнэт хотод төрсөн
- 1992-2002 онд Эрдэнэт хотод ерөнхий боловсролын дунд сургууль
- 2002-2006 онд ШУТИС-ийн ҮТДС-д нэхмэлийн үйлдвэрийн технологи инженер мэргэжил эзэмшсэн, бакалавр зэрэгтэй
- 2006 оны 8 сараас “Улаанбаатар хивс” ХК-д ээрэх цехийн инженер
- 2007 – 2011 онд “Улаанбаатар хивс” ХК-д үйлдвэрлэлийн менежер
- 2011 оноос “Улаанбаатар хивс” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

“Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн товч намтар :

1. Өлзийт овгийн Цэвэгжавын ЭНХБОЛД \Хувьцаа эзэмшигч бус\

- 1985 онд Эрдэнэт хотод төрсөн.
- 1966 онд Сүхбаатар аймгийн Мөнххаан суманд төрсөн.
- 1974-1984 он – Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын дунд сургууль
- 1985-1994 оны Киев хотын Политехникийн дээд сургууль төгссөн, бакалавр,
Магистр
- 1996 он – ГЕГ, Гаалийн байцаагчдын эрх олгох сургалт / 6 сар /
- 2004 он – СЭЗДС, Бизнесийн удирдлагын курс /3 сар/
- 1996 -2006 он - Гаалийн Ерөнхий Газар, Гаалийн хяналт шалгалтын улсын байцаагч
- 2006 -2010 он - “Зотол групп” ХХК, дэд захирал.
- 2010 оноос хойш - “АМГЛА” ХХК, ерөнхий захирал.
- 2000 оноос хойш “Математик сэтгэлгээг хөгжүүлэх Ц.Энхболд сан”-гийн Тэргүүнээр ажиллаж жил тутам Сүхбаатар аймагт Зүүн бүсийн Математикийн Олон улсын олимпиад зохион байгуулж байна.
- 2012 оноос –“ЭБМАТ” ХХК-ийн захирал
- 2010 онд Боловсролын яамны “Боловсролын тэргүүний ажилтан” цол, тэмдэг
- 2013 онд Санхүү эдийн засгийн яамны “Эдийн засгийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг
- Орос, англи хэлтэй, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

2. Хонгорууд овогтой Гомбодоржийн **БАТХҮРЭЛ**

- 1955 онд Сүхбаатар аймгийн Наран суманд төрсөн
- 1973 онд ерөнхий боловсролын дунд сургууль
- 1978 онд МУИС-ийг төгссөн, “Аж үйлдвэрийн эдийн засагч, зохион байгуулалт” бизнесийн удирдлага
- 1992 онд магистр
- 2002 онд ШУТИС-ийн профессор
- 1998 онд ШУТИС-ийн дэд профессор
- 2011 онд Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (Sc.D)
- 2015 онд МУ-ын Гавьяат эдийн засагч болсон.
- 1978-1984 онуудад ТИС-д багш
- 1984-1987 онуудад Улаанбаатар хотын Эвлэлийн Хорооны хэлтсийн эрхлэгч
- 1987-1991 онуудад Хотын намын хороонд улс төрийн ажилтнаар тус тус ажиллаж ирсэн
- 1991 оноос ТИС-ийн Компьютерийн Менежментийн дээд сургуульд албаны дарга, дэд захирал, тэнхимийн эрхлэгч
- 2002 оноос ШУТИС-ийн Механик-Инженерийн дээд сургуулийн захирал
- 2007 оноос ШУТИС-ийн КТМС-д профессор, тэнхимийн эрхлэгч
- 2010-2015 онд ШУТИС-ийн КТМС-ийн захирал
- 2015-2016 онд БУХС-ийн захирал
- 2016-2017 онд ШУТИС-ийн БУХС-ийн Бизнесийн удирдлагын салбарын зөвлөх профессор
- 2011-2019 онд Монголын эдийн засаг, бизнесийн сургуулиудын консорциумын ерөнхийлөгч
- 2017 оноос ШУТИС-ийн БАТС-ийн профессороор ажиллаж байна

3. Ёндонжамцын **ЭНХТӨР**

- 1961 онд Хөвсгөл аймгийн Рашаант суманд төрсөн
- 1979 онд ерөнхий боловсролын дунд сургууль
- 1985 онд Политехникийн дээд сургууль төгссөн, Хөнгөн үйлдвэрийн инженер-технологич мэргэжилтэй
- 1989-2003 онд “Эрдэнэт хивс” ХК-д менежер, цехийн дарга, ээрэх үйлдвэрлэлийн дарга, үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал
- 2004- 2011 онд “Сүү” ХК-ийн дэд захирал.
- 2011 оноос “Улаанбаатар хивс” ХК-ийн захирлын зөвлөх
- Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.